



“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.07.18 № 05/5812  
танай 2019.07.03-ны № 1/1622 -Т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

“УБЦТС” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний албаны ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Цэлээбямбын Батсүрэнгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. “УБЦТС” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний албаны ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагад цахилгааны инженер мэргэжилтэй байх гэж заасан байхад Ц.Батсүрэн нь програм хангамжийн инженер мэргэжилтэй буюу ерөнхий шаардлагыг хангаагүй,

2. Гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Би Ти Эс Эн” ХХК-ийн үүсгэн байгуулагч, 100 хувийг эзэмшигч, гүйцэтгэх захирлаар Ц.Батсүрэн бүртгэлтэй ба “УБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нар нь 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр №2017/427 дугаартай “Төрийн тусгай хамгаалалттай газруудын цахилгаан хангамжийн дэд өртөөнүүдийг хяналт, мэдээллийн системд холбох ажлын материал нийлүүлэх” 42,8 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулж, бараа, материал нийлүүлж 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр уг гэрээг дүгнэсэн, “Энержи Стандарт” ХХК-ийн захирал Д.Рэнцэндорж, “УБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нар нь 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр №2018/120 дугаартай “Хяналт мэдээллийн скада системийн сэлбэг нийлүүлэх” 28,2 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулахад нийлүүлэгчийг төлөөлж менежер ажилтай гэх Ц.Батсүрэн гэрээнд гарын үсэг зурсан байгаа зэрэг нь “УБЦТС” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний албаны ахлах мэргэжилтний эрхлэх асуудлын хүрээнд албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан “нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан

үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал"-ыг бий болгохоор байна.

Иймд нэр дэвшигч Ц.Батсүрэн нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсч болох тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,  
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШВААТАР